

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН
БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ Э. САРАНЧИМЭГИЙН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛИЙН ТАЙЛАН.**

**1. ТӨЛӨВШИЛ
ОРОЛЦОО:**

Ангидаа болон сургууль дээр мөрдөх дэгийг хамт олноороо ярилцаж зохиогоод мөрдөн ажиллаж байна.

Ангийн жижүүр хийхэд хүүхэд бүр оролцож хэвшсэн.

Дэг баримтлахад суралцагч суралцагчдаа шаардлага тавьж сурч байгаа.

Сургуульд байгаа үедээ бусдад саад болохгүй, жагсаж явж хэвшиж байна.

Авьгааслаг 23” урлагийн наадамд 20 сурагчийг сонгон “Найрал дуу”, “Хөгжимт хөдөлгөөн” гэсэн 2 төрөлд оролцуулж тэргүүн байранд шалгарсан.

Чөлөөт үзүүлбэрийн төрөлд сурагч Ж. Амарлин Балет- тэргүүн байранд шалгарлаа.

Сурагч О. Ундрах – Хөтлөгч сурагчаар шалгарлаа.

- Анги хамт олноороо Үндэсний түүхийн музей үзэж. “Үндэсний түүхийн музей- миний нүдээр” СЭТГЭГДЭЛ бичих, ТАЛАРХАЛ бичиж, зургийн үзэсгэлэн гаргасан.
- “СЭТГЭХ ЧАДВАРЫН НАМРЫН СОРИЛГО 2018” олимпиадад амжилттай оролцож 3 сурагч ТОП үнэлгээ, 3 сурагч САЙН үнэлгээ авч амжилттай оролцлоо. Ж.

Амарлин ТОП

- Э. Мөрөн ТОП
- Ө. Мишээл ТОП
- Б. Баярбилэг САЙН
- Г. Сараана САЙН
- Б. Амин-Эрдэнэ САЙН

- АЛТАН ХОНХ тэмцээнийг ангидаа зохион байгуулж ялагчаа тодруулсан. “МАТЕМАТИК- МИНИЙ ХЭРЭГЛЭЭ” олимпиадад анги хамт олноороо амжилттай оролцож 80 % гүйцэтгэлтэй шалгагдан II шатанд шалгаран оролцох эрх авсан. МУБИС багш доктор, профессор Ц. Нямжавын нэрэмжит” Математик –миний хэрэглээ “ олимпиадын 2-р шатанд амжилттай оролцож нийслэлд 3-р байранд шалгарсан.

Хувийн амжилтаар Алтан медаль 2 сурагч, Мөнгөн медаль 5 сурагч, Хүрэл медаль 2 сурагч хүртсэн. Үүнд: Сурагч Ж. Амарлин – алт, Б. Номин –Эрдэнэ- алт, Ө.

Мишээл- мөнгө, Б. Сараана- мөнгө, Б. Амин-эрдэнэ- мөнгө, Г. Сараана- мөнгө, О.Нандин- Эрдэнэ- мөнгө, Э. Мөрөн- хүрэл, О. Сувд- хүрэл медаль хүртсэн.

“Би ном унших дуртай” 14 хоногийн ном унших аян зарлаж зарлаж дүгнэв. Сурагч Э.Галцог , Э. Мөрөн, О, Сувд нар эхний байруудад шалгарч өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнагдсан.

- Охидыг хүндлэх, тэдэнд туслах зөв дадал хэвшил төлөвшиж байгаа. Үүнд : Ангид хувцасны өлгүүрт хөвгүүд охидын хувцсыг өлгөж өгдөг. Сургуулийн бие засах газарт зөв боловсон бие засах талаар байнга хэлж зөвлөж дагуулан сургаж байна.

ДАДАЛ ХЭВШИЛ:

- ✓ Дэгүүдийг ангид байрлуулан өдөр бүр дадал хэвшил болгох ажлыг хийж ирснээр сурагчдын 85% нь дэгүүдээ амжилттай хэрэгжүүлж байна.
- ✓ “ МИНИЙ ОРОЛЦОО- ЦЭВЭР ОРЧИН” аяны хүрээнд Өдөр бүр 4,4 –өөр жижүүр сурагч хийж ангиа цэвэрлэн, А\ Ц дарга Б. Энхжин, Б. Нандинэрдэнэ нар маш идэвхтэй самбар ажиллуулж дүгнэж хэвшлээ.

- ✓ Гэрийн даалгаврын комисс гарган өдөр бүр даалгавар шалгаж, бие биедээ шаардлага тавьснаар сурагчид гэрийн даалгавраа тогтмол хийж хэвшиж байна. Сурагчид хичээлийн цагийг баримтлан, багшийн удирдлага дор
ЗАН ЧАНАР :

“ Миний зөв дадал хэвшил” “ Эрүүл орчин- Миний оролцоо “ аяныг явуулснаар

- Сургууль орчинд болон олон нийтийн газар биеэ зөв авч явах
 - Мэндэлж, хүндэлж сурах
 - Найрсаг, нөхөрсөг зөв үг хэллэг хэрэглэх
 - Найз нөхөддөө туслах, хамтран ажиллах
 - Буруу зүйл хийсэн бол уучлалт гуйж сурах, баярласнаа илэрхийлж сурах
 - Бусдын яриаг анхааралтай сонсох
 - Найз нөхдөөрөө бахархах
 - Өөртөө итгэлтэй байх
 - Биеэ зөв боловсон авч явах тал дээр эерэг өөрчлөлтүүд гарч байгаа ба зан харилцааны өөрчлөлттэй зарим нэг сурагчидтай ганцаарчлан ажиллаж үр дүнг ажиглаж байна.
- ✓ идэвхтэй сайн суралцаж байна.
 - АХИЦ АМЖИЛТ

Хичээл бүрээр МЧС авч анализ хийж, ахиц амжилтыг тооцон ажиллаж байна.

Дүгнэлт: Орос хэлний сургалттай 2а ангийн сурагчдаас авсан математикийн шалгалтанд дүгнэгдвэл зохих 66 – 63 сурагч шалгагдсан. **Дүн үнэлгээг нэгтгэвэл:** Ангийн нийт авбал зохих 630 онооноос 433.5 оноо авч гүйцэтгэл 67% -тай дүгнэгдсэн. VIII ТҮВШИН - 17, VII ТҮВШИН- 10, VI ТҮВШИН- 8, V ТҮВШИН- 11, IV ТҮВШИН- 6, III ТҮВШИН- 2, II ТҮВШИН -4, I ТҮВШИН- 6 суралцагч хангасан байна. Эндээс харахад I– III түвшний шалгуур хангасан 12 суралцагчтай тусгайлан ажиллах шаардлагатай.

Даалгавар тус бүрээр авч үзвэл: Өгүүлбэртэй бодлого даалгаврын гүйцэтгэл

54 % , геометрийн агуулгатай даалгавар болох тэгш өнцөгт дүрс зурах, тэнцүү хуваах – 68%, мөн орон ангиар, аравт нэгжээр задлах даалгавар – 62% шалгагдсан байна. Иймээс цаашид дээрх даалгаврууд дээр түлхүү ажиллах, нэмэлт давтлага өгөх, эцэг эхэд зөвлөгөө өгөх, хамтран ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Орос хэлний сургалттай 2а ангийн сурагчдаас авсан математикийн шалгалтанд дүгнэгдвэл зохих 66 – 60 сурагч шалгагдсан. Дүн үнэлгээг нэгтгэвэл: Ангийн нийт авбал зохих 1080 онооноос 767 оноо авч гүйцэтгэл 71% -тай дүгнэгдсэн.

- VIII ТҮВШИН - 13,
- VII ТҮВШИН- 11 ,
- VI ТҮВШИН - 10,
- V ТҮВШИН - 10
- IV ТҮВШИН - 7,
- III ТҮВШИН - 4,
- II ТҮВШИН -3,
- I ТҮВШИН - 2 суралцагч хангасан байна.

- Эндээс харахад гарааны үнэлгээн дээр I– III түвшний шалгуур хангасан 12 байсан бол хагас жилийн үнэлгээгээр 9 болж цөөрсөн ба эдгээр суралцагчтай тусгайлан ажиллах шаардлагатай.
 - Анхаарах шаардлагатай сурагчдын шалтгааныг тодруулж эцэг эхтэй хамтран ажиллаж байна.

2А АНГИЙН МАТЕМАТИК ,МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ДҮН

	VIII	VII	VI	V	IV	III	II	I	Гүйцэтгэл
- МАТ	49	9	6	1	1				92%
- МХ	50	10	4	2					93%

2. АВЪЯАСЫГ НЭЭН ИЛРҮҮЛСЭН БАЙДАЛ

- “Авьяаслаг 23” урлагийн наадамд ТЭРГҮҮН байр
- Авьяас сонирхлын судалгаа авсан.
- Авьяаслаг 23” урлагийн наадамд 20 сурагчийг сонгон “Найрал дуу”, “Хөгжимт хөдөлгөөн” гэсэн 2 төрөлд оролцуулж тэргүүн байранд шалгарсан.

Чөлөөт үзүүлбэрийн төрөлд сурагч Ж. Амарлин Балет- тэргүүн байранд шалгарлаа.

Сурагч О. Ундрах – Хөтлөгч сурагчаар шалгарлаа.

ЭЦЭГ ЭХИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

“ ЭЦЭГ ЭХ ТАНЫГ СОНСЪЁ” санал асуулга явуулж нэгтгэн дүгнэж цаашдын ажлаа төлөвлөв. Эцэг эхчүүдийг 5 баг болгон хувааж ажлаа төлөвлөн хамтран ажиллаж байна. Үүнд: 1баг төлөвшил баг, 2-р баг Ахиц амжилт баг , 3-р баг Авьяас баг, 4-р баг Сэтгэл ханамж баг, 5-р баг Эрүүл мэндийн баг

Эцэг эхийн хурлаа тогтмол хийж, цаг үеийн асуудлаар заавар зөвлөгөө өгч ажилладаг.

“ Хүүхэд нэг эрдэнэ, Хүмүүжил мянган эрдэнэ “ СХ сургалт явуулсан. 66 эцэг эх хамрагдлаа.

Эцэг эх,олон нийтийн оролцоонд тулгуурлан ангийн сурагчдын дунд дараах ажлуудыг хамтран зохион байгуулж явууллаа. Үүнд:

- ✓ Уламжлалт урлагийн наадамд бэлтгэх,түүнд амжилттай оролцоход хамтран ажиллав.
- ✓ Багш-Эцэг эх өдөрлөгийг I багийн эцэг эхчүүд амжилттай сайн зохион байгуулав.
- ✓ Сурагчдын дунд явуулсан “АХА ” танин мэдэхүйн тэмцээнийг хамтран зохион байгуулсан.
- ✓ Ангийн сурагчдыг “Амны хөндийн эрүүл ахуй” сэдэвт сургалт, үзлэгт оруулав.
- ✓ “Үдийн цай”-ны амтлагаат өдөрлөгт 5 эцэг эхийг хамруулав.
- ✓ Сэтгэл ханамжийн судалгаа
- ✓ Автобусаар зорчдог сурагчдын судалгаа
- ✓ “Дэг журмыг хэвшүүлэх ”аяны хүрээнд хяналтын хуудас олголт,хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Эцэг эхэд зөвлөн туслах,тэднийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор 2 удаагийн нээлттэй ярилцлага,хэлэлцүүлэг зохион байгуулсан.

- ✓ Эцэг эхийн хурал – 5 удаа
- ✓ Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх хичээл – 2 удаа
- ✓ Багш-эцэг эх өдөрлөг – 5 эцэг эх ирж хичээл зааж сэтгэгдлээ үлдээсэн.

- ✓ Үдийн цайны хяналт – 2 удаа
- ✓ Эцэг эхийн багийн ажлууд – 5 удаа
- ✓ Сурагчдын хувийн онцлог, зан чанарыг судлах зорилгоор эцэг эхчүүдээс асуулга авч ажилдаа тусган ажилласан.
- ✓ Бүх сурагчдаас “Эрсдэл-”ийн судалгаа авч, дүгнэлт хийн ажиллаж байна

ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ ХАРИЛЦАА

- Шүдний эрүүл ахуй – Сурагч Баярбилэгтийн ээж Ариунаа АШУИС оюутан багш нартай хамтран үзлэг оношлогоо хийж, кино үзүүлж, жүжигчилсэн тоглолт хийсэн нь цаг үеэ олсон сайхан ажил болсон.
- Сурагчдын аюулгүй байдал онцгой анхаарч хичээлээс хоцроохгүй, цагт авч байхыг анхааруулж гарын үсэг авсан.
- Мөн соронзны талаар мэдээлэл өгч гарын үсэг авав.
- Сурагчдын амралтын үеэр чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарах зөвлөгөө гарын үсэг авав.

Эцэг эхтэй хамтран цонхонд АГААР ШҮҮЛТ байрлуулав.

- ❖ Мэндлэх, хүндлэх, талархах дэгийг өдөр бүр хэвшүүлэх ажлыг хийж байна.
- ❖ Судалж буй хэлээрээ мэндчилэх
- ❖ Зөв харилцаа, зан чанартай сурагчдыг урамшуулах, магтах үйл ажиллагааг хийснээр сурагчид бие биенээсээ суралцах сайн тал ажиглагдаж байна.
- ❖ Өдөр бүр тарахад замын хөдөлгөөний дүрмийн тухай санамж өгч байна.

ЭРҮҮЛ ОРЧИН:

- ❖ Ухаалаг, гар утасны хор хөнөөлийн талаар ханын сонин гаргасан.
- ❖ Эрүүл аюулгүй ажиллагааны дүрмийг байрлуулав.
- ❖ Эцэг эхтэй хамтран цонхонд АГААР ШҮҮЛТ байрлуулав.
- ❖ Ангийн агааржуулагчийг тогтмол, тодорхой хугацаагаар ажиллуулж хэвшлээ.

МӨНГӨН ХӨӨС аяныг өрнүүлж эцэг эхчүүд хүүхдүүдийн хамтаар 7 хоногт нэг удаа ангидаа их цэвэрлэгээний өдөр болгон зарлаж, идэвхтэй ажиллаж байна.

БАГШИЙН ХӨГЖИЛ ОРОЛЦОО, СУРГАЛТ

“Анги удирдах урлаг” “Эцэг эхийн оролцоо” “Ангийн дарга нарын анхдугаар зөвлөгөөн” – өөс гарах зөвлөмж боловсруулсан. Багийн ахлагчаар ажилласан. Зөвлөх багш нар “Мэргэжлийн зэрэг авах” багш нарын материалыг хянаж зөвлөн ажилласан.

Залуу багш нарын хичээлд сууж, хөтөлбөр боловсруулалтанд зөвлөн тусалж ажилласан.

5-р ангийн багш нартай уулзалт зохион байгуулж төгсөх ангийн шалгалтанп хэрхэн бэлтгэх талаар зөвлөн ажиллав.

Сургууль, сургалтын алба, заах аргын нэгдэл, секцээс зохион байгуулж буй хурал цуглаан, сургалт семинарт цаг тухай бүрт нь хамрагддаг болно. Үүнд:

ЗАН, секцийн ахлагчийн хуралд 1 дэх өдөр бүр

АУБ нарын хуралд -4 удаа

ЗАН-ийн хуралд – 5 удаа

Секцийн ажлыг 7 хоногт 2 удаа зохион байгуулж багш нартайгаа хамтран ажиллаж байна.

Сургуулийн захиргаа сургалтын албанаас зохион байгуулсан “Цэнэглэх цаг” үйл ажиллагаанд 6 удаа оролцсон.

Moodle-ийн сургалтанд 10 удаа хамрагдсан. Шалгалтыг 93% шалгагдаж сертификат авсан.

Moodle праграммд бүх хичээлийн нэгж, ээлжит хөтөлбөрөө хийсэн.

БЗД-ийн 97 дугаар сургууль дээр зохион байгуулсан “Эцэг эхийн оролцоо” сэдэвт сураглтанд хамрагдсан.

Мөн НБГ –аас зохион байгуулсан Эрүүл мэндийн сургалтанд хамрагдаж, секцийн багш нартаа сургалт явуулсан.

Өмнө говь аймаг, Дорнод аймгийн багш нарт арга туршлагаа түгээн хамтран ажилласан.

МУБИС-ийн дадлагажигч 2 оюутныг хариуцан дадлагын хугацаанд нь хамтран ажиллаж, арга туршлага, арга зүй, сурагчидтай ажиллах арга зэрэгт дадлагажуулан ажилласан.

ДҮГНЭЛТ:

2018 - 2019 оны хичээлийн жилийн Үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу ажлаа төлөвлөж явууллаа. Нийт 21 ажил төлөвлөснөөс 24 ажил хийгдсэн байна. Үүнээс шинээр санаачлан буюу цаг үеийн 3 ажил нэмэгдэн зохион байгуулагдсан байна. Төлөвлөсөн болон хийгдсэн үр дүнтэй ажлуудаас харахад сэтгэл ханамж өндөр байгаа. Цаашдаа Moodle программ дээр ажиллах чадвараа улам нэмэгдүүлэн хичээл бүрээр, судлагдахууны ерөнхий болон тусгай чадвар бүрээр оношлох үнэлгээ хийхэд нэлээн голлон ажиллах шаардлагатай гэж үзлээ.



СЭТГЭХ ЧАДВАРЫН НАМРЫН СОРИЛГО – 2018 ОЛИМПИАД

2А АНГИЙН СУРАГЧ Ж. АМАРЛИН - **ТОП ҮНЭЛГЭЭ**

Э. МӨРӨН - **ТОП ҮНЭЛГЭЭ**

Ө. МИШЭЭЛ - **ТОП ҮНЭЛГЭЭ**





АШУУИС-ЫН БАГШ ОЮУТНУУДАЙ ХАМТАРЧ “ ШҮДНИЙ ЭРҮҮЛ АХУЙ” СЭДВЭЭР СУРГАЛТ ЯВУУЛЖ , УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ОНОШИЛГОО, ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ ХАМТРАН АЖИЛЛАЛАА..





“АВЪЯАСЛАГ 23” урлагийн наадам. 2А ангийн сурагч Э. Ундрах



“АВЪЯАСЛАГ 23” урлагийн наадамд 2А ангийн сурагч Ж. Амарлин

Балет - ТЭРГҮҮН БАЙР

ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ СУРАЛЦЬЯ





МУБИС, Багшийн сургуулийн багш доктор, профессор Ц. Нямжавын нэрэмжит МАТЕМАТИК МИНИЙ ХЭРЭГЛЭЭ уралдаанд 2А ангийн сурагчид анги хамт олноороо амжилттай оролцож нэгдүгээр шатанд ТЭРГҮҮН байр , ӨРГӨЖЛӨЛ, ЦОМ хүртсэн.



- МУБИС, Багшийн сургуулийн багш доктор, профессор Ц. Нямжавын нэрэмжит МАТЕМАТИК МИНИЙ ХЭРЭГЛЭЭ уралдаанд 2А ангийн сурагчид анги хамт олноороо хоёрдугаар шатанд шалгаран амжилттай оролцож нийслэлд ГУТГААР байр эзэллээ.
- Мөн хувийн амжилтаар 2 сурагч АЛТ медаль, 5 сурагч МӨНГӨ медаль, 2 сурагч ХҮРЭЛ медаль хүртсэн сайхан амжилт үзүүллээ.



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН 2В АНГИЙН НЭРЭМЖИТ “ГАР БӨМБӨГ”-ИЙН ТЭМЦЭЭНД
АМЖИЛТТАЙ ОРОЛЦОН ШИЛЖЭН ЯВАХ ЦОМЫН ЭЗЭД



НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН 2В АНГИЙН НЭРЭМЖИТ “ГАР БӨМБӨГ”-ИЙН ТЭМЦЭЭНД
ЭРЭГТЭЙ БАГ ТАМИРЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОН “МӨНГӨН МЕДАЛЬ”.



СУРГУУЛИЙН ШАТРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД

2А –АНГИЙН СУРАГЧ О.ГАЛЦОГ - ХҮРЭЛ МЕДАЛЬ

Г.САРААНА - ХҮРЭЛ МЕДАЛЬ



2А-АНГИЙН СУРАГЧИД СУРАГЧДЫН АМРАЛТАА НОМТОЙ НӨХӨРЛӨН ҮР БҮТЭЭЛТЭЙ ӨНГӨРҮҮЛЭХ ЗОРИЛГООР **БЯЦХАН НОМ** ХИЙЖ, ҮЗЭСГЭЛЭН ГАРГАЛАА



СУРАГЧДЫН ТАНИН МЭДЭХҮЙН МЭДЭЛГИЙГ БАТАТГАН ХӨГЖҮҮЛЭХ
ЗОРИЛГООР “АЛТАН ХОНХ” ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛСАН



ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЯРЫГ УГТАН “БИ ЭЭЖДЭЭ ХАЙРТАЙ”
МЭНДЧИЛГЭЭ



